

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга
Ц.Мөнхнасан

Илтгэх хугацаа: 45 минут

Эрхэм хүндэт Төлөөлөгчид өө !

2018 онд манай аймаг 27.7 мянган өрх, 94.9 мянган хүн амтай болж мал сүргийн тоо 5.6 хувиар өсч, 5.2 сая толгой мал тоолуулж улсдаа тэргүүлэх аймгуудын тоонд орж байна.

Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 11.9 хувиар, бүтээгдэхүүн үйлдвэрлэл өнгөрсөн оны мөн үеэс 7.2 хувиар өслөө.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдаж, аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 4 бодлогын хүрээнд 162 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээс өнөөдрийн байдлаар биелэлт 86.7 хувьтай байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг товч байдлаар илтгэн танилцуулж байна.

НЭГ.ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

1.1.Үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр:

Эрдэнэбулган суманд байгуулагдах ноос угаах үйлдвэрийн суурь судалгаа хийгдэж, барилгын ажил эхэлсэн байна.

2018 онд жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх сангаас 10 аж ахуй нэгж, иргэдэд 452.0 сая төгрөгийн санхүүжилт олгоод байна. Мөн сум хөгжүүлэх сангаас 10 суманд мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, газар тариалан, эмийн сангийн чиглэлээр нийт 104 аж ахуйн нэгж, иргэдэд 727.458.80 төгрөгийн зээлийг олгосон байна.

Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэдийг хямд түрээстэй ажлын байраар хангах, орон нутагт өөрийн нэрийн бренд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, сурталчилах, борлуулах зорилгоор 5 давхар 2700 м² талбай бүхий “Архангайд үйлдвэрлэв” худалдаа, үйлчилгээний төвийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар барьж, ашиглалтад оруулахад бэлэн болоод байна.

“Архангай түншлэл-2018” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, нийт 115 аж ахуй нэгж, иргэд оролцон 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг

худалдаалж 90.5 сая төгрөгийн борлуулалтыг хийж, өмнөх оноос борлуулалтын орлого 21.2 сая төгрөг буюу 30.7 хувиар өссөн байна.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Намрын ногоон өдрүүд–2018” нэгдсэн арга хэмжээнд Эрдэнэбулган, Чулуут, Тариат, Хотонт сумын иргэн аж ахуй нэгж оролцож 2.8 тн сүү, сүүн бүтээгдэхүүн худалдаалан 17.0 сая төгрөгийн борлуулалтыг хийлээ.

2018 оны байдлаар хүнсний аюулгүй сав хэрэглэж хэвших талаар 30 гаруй аж ахуйн нэгжид сургалт зохион байгуулж аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гал тогоо, үдийн цайны газрууд хүнсний зориулалтын савыг 100% хэрэглэж хэвшээд байна.

2018-2020 он хүртэлх “Мах сүүний анх дугаар аян”-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллаж байна. Эрдэнэбулган сумын “Бага рашаант” ХХК сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэн сүүний уургийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулан гаргаж жилд 3тн бүтээгдэхүүн зах зээлд худалдан борлуулж байна. Жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх сангаас сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 5 төсөлд 239,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

1.2. Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1120.7 мянган толгой малыг хамруулснаар өвчний гаралт 29.4 хувиар, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 3157.5 мянган толгой мал буюу нийт мал сүргийн 59.6 хувийг хамруулснаар өмнөх онтой харьцуулвал өвчлөл 23.4 хувиар буурсан байна.

Бруцеллэз өвчний тандалт шинжилгээнд нийт 25649 хээлтүүлэгч малыг хамруулж, 140 эерэг урвал үзүүлсэн дээжийг баталгаажуулан зохих арга хэмжээг авлаа.

Ихтамир, Өндөр-Улаан, Тариат, Чулуут сумдын мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд тус бүр 11.4 сая төгрөгийн үнэ бүхий техник, тоног төхөөрөмж, 16 суманд мал угаалгын зөөврийн ванн, 19 сумын мал эмнэлэг, үржлийн тасагт мотоцикль олголоо.

Мал угаалгын суурин ванныг Булган, Ихтамир суманд барьж байна.

Хотонт үржлийн хэсэг, Тамир үүлдрийн хэсгийн 13.3 мянган толгой хээлтэгч, бог малын 18.6 мянган толгой хээлтүүлэгч, 9.3 мянган толгой сарлаг үхэр нийт 41.2 мянган толгой малд үзлэг ангилалт хийснээр цөм сүргийн малын тоо толгойг нэмэгдүүлж, чанартай хээлтэгч, хээлтүүлэгчийг бойжуулах нөхцөлийг бүрдүүлсэн.

Аймгийн 8 суманд 9 мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж бий болж, бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж 5357 толгой хээлтүүлэгчийг төвлөрүүлээд байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр Ихтамир, Хангай, Эрдэнэмандал, Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Батцэнгэл, Төвшрүүлэх, Өлзийт, Өгийнуур, Хашаат сумдын 60.0 мянган га бэлчээрт үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг 82.5 хувьтай зохион байгууллаа.

Улсын төсвийн хөрөнгөөр 6, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 16, малчдын санаачилгаар 1 нийт 23 худгийг шинээр, 10 худгийг сэргээн засварлаж 40.0 мянган га бэлчээрийг усжууллаа.

Нийт 10766 га талбайд тариалалт хийж, ургацын хэмжээ өмнөх оныхоос 1777 тн буюу 40.7 хувиар нэмэгдлээ.

Цэнхэр суманд 240 м² талбай бүхий шилэн хүлэмж байгуулагдаж, 10420 м² талбай бүхий 119 хүлэмжинд нарийн ногоо тариалсан нь өмнөх оныхоос 2400 м² талбайгаар, хураасан ургац 12 тн-оор тус тус нэмэгдсэн.

Малчдыг мэдлэгжүүлэх аяныг өрнүүлэн, аймгийн “Малчдын зөвлөгөөн”-ийг Ихтамир, Өндөр-Улаан, Эрдэнэмандал, Батцэнгэл сумдад бүсчилэн зохион байгуулж, 1300 гаруй малчдыг хамруулан салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцуулан, мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөлөө.

1.3.Дэд бүтэц, барилга, хот байгуулалтын чиглэлээр:

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр Эрдэнэбулган суманд хоногт 3000 м³ хүчин чадал бүхий механик биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламжийг барих ажил 48%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Дулааны станц барьж байгуулах талаар Солонгос улстай Эрчим хүчний яам хамтын гэрээг байгуулсан. Тус гэрээний дагуу техник, эдийн засгийн үндэслэлийг Кэй Ди Эйч ай /KDHI/ компани монгол хэлээр орчуулж байна.

Стандарт хэмжил зүйн хэлтсийн байрыг засварлаж, цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбох ажлыг 24 сая төгрөгөөр, 72 айлын орон сууцны цэвэр бохир усны шугам сүлжээг шинэчилж, 16 дугаар байрыг цэвэр, бохир усны шугаманд холбох ажлыг 58.8 сая төгрөгөөр, Эрдэнэмандал сумын нэгдсэн шугам сүлжээний ажлыг 143.0 сая төгрөгөөр, Цахир сумын багийн төвийн барилгыг 62.9 сая төгрөгөөр, Төвшрүүлэх сумын Хөх сүм багийн төвийн барилгыг 62.6 сая төгрөгөөр, Цэнхэр сумын Нэгдсэн багийн төвийн барилгыг 67 сая төгрөгөөр, Батцэнгэл сумын Дэл багийн төвийн барилгыг 40.0 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэлээ.

Цэцэрлэг хотын гудамж талбайн тохижилт засвар үйлчилгээний ажлыг хийх зорилтын хүрээнд ЗДТГ-ын баруун, зүүн саадны тохижилт, 24-ийн уулзвараас Наран төв хүртлэх уулзварын хайсны ажил, Барилгачдын саад, Булган уулын

тохижилт, Бөх билэгтийн саадны засвар шинэчлэлтийн ажил хийгдэж ашиглалтад хүлээлгэн өгөөд байна.

Аймгийн төвийн 200 гаруй гэрэлд засвар шинэчлэлтийг хийж, Эрдэнэбулган сумын 4, 7-р багт 32 ширхэг гэрэл шинээр суурьлуулж, Нисэхийн тойргоос Эмнэлгийн уулзвар, Захын уулзвараас музейн 2 талаар, Булган уул хүртэлх замуудад нийт 180 ширхэг гоёлын гэрэлтүүлэг тавьж, 1-р багийн улсын чанартай авто зам дагуух айл өрхийн нүүрний хашааг шинэчлэн засварлах ажлыг хийж гүйцэтгээд байна.

Улсын төсвийн 6.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Хөгжимт драмын театрын барилга угсралтын болон дүүргэлтийн ажил хийгдэж барилгын ажлын гүйцэтгэл 65%-тай явагдаж байна.

Дэлхийн банкны 4.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хийгдэх “Эрчим хүч-2” төслийн хүрээнд Цэцэрлэг хотын 0.4 кВ-ын цахилгаан түгээх агаарын 90км шугам сүлжээг шинэчлэх, 4ш дэд станц барих, 400 гаруй аж ахуйн нэгж, байгууллага, 5210 хэрэглэгчийг смарт тоолуурт холбох, ухаалаг тоолуур суурилуулах төслийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулагдаж дууслаа.

Мөн тус төслийн хүрээнд хэрэглэгчдийн мэдээллийн бааз цуглуулах ажил хийгдээд 90%-ийн гүйцэтгэлтэй, борлуулалт санхүүгийн программ шинэчлэх ажлын бэлтгэл ажил дуусаад байна. Шугам сүлжээ шинэчлэх ажлын гүйцэтгэгч шалгаруулах тендер зарлагдан ажлын гүйцэтгэгч шалгаран төслийн нэгжтэй хамтран ажиллаж байна. 2018 онд хийгдэх Ихтамир сумын Хан-өндөр багт баригдах 10 кВ-ын АШ, 10/0,4 кВ-ын дэд станцын ажлын гүйцэтгэл 70%-тай, Тариат сумын Бөөрөлжүүт багт баригдах 10 кВ-ын агаарын шугам, 10/0,4 кВ-ын дэд станцын ажлын гүйцэтгэл 90%-тай, Өгийнуур, Хан хэнтийн цогцолборийн цахилгаан дамжуулах агаарын 35 км шугам хийх ажлын гүйцэтгэл 95%-тай явагдаж байгаа бөгөөд энэ ондоо багтан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Ундны усны 2 дахь эх үүсвэрийг бий болгох ажлын даалгаврыг Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон шинэ Наран хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаатай уялдуулан цэвэр усны 2-р эх үүсвэрийн байршлыг тогтоож төлөвлөлтөд тусгуулаад байна.

Аймгийн төвд ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилга байгууламжийг буулгаж шинээр орон сууц барихаар 4-н байршилд дахин төлөвлөлтийн зураг төсөл хийлгэхээр зургийн даалгавар боловсруулаад байна.

Дэлхийн зөн олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар Ихтамир сумын сургууль, дотуур байрыг цэвэр усны нэгдсэн шугам сүлжээнд холбож, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эмнэлгийн барилгын цэвэр, бохир усны шугам сүлжээг засварлаж ашиглалтад оруулсан.

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын материалын лаборатори нь 2 жилээр итгэмжлэгдлээ.

Аймаг, сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөж, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахаар “ӨРХ” ХХК шалгарч эхний шатны тайланг боловсруулж дуусаад байна.

2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар 22 байршилд 5.35 га газар, жимс жимсгэнэ, мод үржүүлгийн зориулалтаар 4 байршилд 7га газар, аялал жуулчлалын зориулалтаар 1 байршилд 1га, дуудлага худалдаагаар 9 иргэн аж ахуйн нэгж байгууллагад 1511 га газар олгоод байна. Аймгийн хэмжээнд дуудлага худалдаанаас 273.0 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Эрдэнэбулган суманд зураглал хаягжуулалтыг хийх ажлын гүйцэтгэгчээр “Мэф сүрвэй” ХХК шалгаран хаягжуулалтын ажил эхлээд байна.

Жэрэс олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар баригдаж буй “Түр хамгаалах байр”-ыг энэ ондоо багтаан ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

Цэцэрлэг хотын доторх орон нутгийн чанартай авто замын засвар арчлалт, нөхөөсийг хийж дуусгаад байна.

Эрдэнэбулган сумын 1-р багт төмөр бетон гүүр, 7-р багийг Булган хангай хороололтой холбосон зам гүүр, Хангай сумын ухаа гүвээний голд шинээр модон гүүрийг барьж ашиглалтад оруулсан.

Орхон гол Ихтамир чиглэлийн гүүр, Өгийнуур-Өлзийт-Хайрхан-Хөвсгөл чиглэлийн хатуу хучилттай авто замын хөрс хуулалт, далан хийгдлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ихтамир сумын төвд хатуу хучилттай 1.7 км авто зам, Тариат сумын Дасгалын 5.7 км шороон замын засвар шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгээд байна.

1.4. Санхүү төсөв, өмчийн харилцаа, худалдан авах ажиллагааны чиглэлээр:

Аймгийн санхүү төсвийн тогтвортой байдлыг хангаж орон нутгийн төсвийн орлогын даалгаврыг жигд ханган биелүүлж, татварын ногдуулалтыг оновчтой хийх, татварт бүрэн хамруулах ажлын хүрээнд шинээр байгуулагдсан 48 аж ахуйн нэгж байгууллага, 21 төрийн бус байгууллагыг, үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн гэрчилгээ авсан 32 иргэнийг татвар төлөгчөөр бүртгэж татварт хамруулж татварын бааз суурийг өргөтгөлөө.

2018 онд орон нутгийн төсвийн орлогод төлөвлөгөөгөөр 6726.0 сая төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 8156.0 сая төгрөг байхаар урьдчилсан нөхцөл бүрдсэн байна. Энэ онд хадгаламжийн хүүгийн орлогоос суутган авсан хөрөнгийн орлогоор сумдад 900.0 сая төгрөг, газрын дуудлага худалдааны орлого 260.0 гаруй сая төгрөг төвлөрсөн нь орон нутгийн төсвийн орлого давж биелэхэд нөлөөлсөн юм.

Татвар төлөгчийн сегмент тус бүрээр эрсдэл тооцож, эрсдэлд суурилсан татварын хяналт шалгалтыг зохион байгуулж, 30 татвар төлөгчийн үйл ажиллагааны чиглэл, түүнд анхаарах асуудлыг тодорхойлон сегмент бүрд тохирсон арга техник, журмыг баримтлан хяналт шалгалтыг хийсэн байна.

Нэмэгдсэн өртгийн урамшууллын системийг аймгийн хэмжээнд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу кассын машинаар үйлчлэх хүрээг нэмэгдүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зөвлөмж өгч, аймгийн Засаг даргын захирамж гаргаж ажилласнаар нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч иргэн, аж ахуйн нэгжийн 95 хувь нь, нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч биш иргэн, аж ахуйн нэгжийн 80 хувь нь төлбөрийн баримтын нэгдсэн системд холбогдон иргэдэд үйлчилж байна.

Татвар төлөгчийн татварын боловсролыг дээшлүүлэх, тэдний үйл ажиллагааны цар хүрээ, борлуулалтын орлогоос хамааруулан сегментийн ангилалд хуваан тэдэнд тохирсон үйлчилгээг үзүүлж иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад 49 удаа сургалт хийснээр 2500 гаруй иргэн хамрагдлаа.

Орон нутгийн төсвийн тэнцвэрт байдлыг хангаж, төсвийн зарцуулалтыг хөтөлбөрт суурилсан арга хэмжээний бодит үр дүнд тулгуурлан санхүүжүүлэх бодлого баримталж тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 40473.5 сая төгрөгийг, орон нутгийн төсвийн байгууллагуудад 28035.7 сая төгрөгийг хөтөлбөр, арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар хуваарилж санхүүжүүллээ.

Төсвийн байгууллагуудын санхүүгийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, төсвийн ил тод, үнэн зөв зарчмыг хэрэгжүүлэх үүднээс төсвийн хөрөнгө, орон нутгийг хөгжүүлэх сан болон сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлын зарцуулалтанд хяналт хийн, дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр зөвлөмж хүргүүлэн, өмнөх хяналт шалгалтын ажлын үр дүнг тооцож ажилласнаар албан шаардлагын биелэлт 96.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрх, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийх ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулах комиссыг томилон ажиллуулж, орон нутгийн өмчит 196 байгууллагын 320 гаруй албан хаагчдыг сургалтанд хамруулан тухайн ажлыг энэ ондоо багтаан дуусгахаар ажиллаж байна.

Орон нутгийн өмчид бүртгэлтэй боловч ашиглах боломжгүй илүүдэл хөрөнгүүдийг хянан үзэж, данс бүртгэлээс хасч, устгах, худалдах, шилжүүлэх ажлыг зохион байгуулж орон нутгийн өмчид бүртгэлтэй барилга, тээврийн хэрэгслийг акталж бүртгэлээс хасч, дуудлага худалдаагаар худалдан борлуулж аймгийн төсөвт 58.9 сая төгрөгийг төвлөрүүллээ.

“Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд орон нутгийн төсвийн удирдлагыг сайжруулах талаар сумдын санхүүгийн албаны ажилтнууд, санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтнүүд зэрэг 50 гаруй албан хаагчыг сургалтад хамруулсан байна.

ХОЁР.ТОГТВОРТОЙ НИЙГМИЙН ХӨГЖИЛ:

2.1. Эрүүл мэндийн чиглэлээр:

Алслагдсан багийн иргэдэд эрүүл мэндийн цогц чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх, бэлгийн замаар дамжих халдвар, сүрьеэ, бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлж халдварын тархалтыг бууруулах зорилгоор Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 10 суманд нарийн мэргэжлийн эмч нарын баг ажиллан нийт 2798 хүнийг хамруулан халдварт өвчтэй илэрсэн 120 гаруй хүнийг хяналтад авч эмчлэн эрүүлжүүллээ.

Хүн амын өвчлөл нас баралтын зонхилох хувийг эзэлдэг, урьдчилан сэргийлэх боломжтой халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах зорилгоор нийт анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын түвшинд артерийн гипертензи, чихрийн шижин, умайн хүзүүний болон хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэг, шинжилгээг хийж, артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих зорилтот бүлгийн 62.7 хувь, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих зорилтот бүлгийн 51.8 хувь, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих зорилтот бүлгийн 56.2 хувь, умайн хүзүүний эсийн шинжилгээнд хамрагдах зорилтот бүлгийн 34.4 хувийг хамруулан оношоор илэрсэн өвчтөнийг хяналтад авч эмчилсэн байна.

2013 оноос эхлэн “Эрүүл мэндийн олимпиад”-ыг 6 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж аймаг, сумдын 20 сургуулийн 77 сурагч, сургуулийн 20 эмчийг оролцуулан зохион байгуулсны үр дүнд сурагчдын эрүүл мэндийн боловсрол жил бүр дээшилж байна.

Хүүхдийн шүд цоорох өвчлөлийг бууруулах, амны хөндийн эрүүл ахуйн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор “Оролцоот эрүүл шүд” аяныг зохион байгуулан Нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн шүдний эмнэлэг, Эрдэнэмандал, Тариат сумдын сум дундын эмнэлгийн шүдний кабинет, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд 2000 гаруй хүүхдэд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эмчилгээ хийж, амны хөндийн эрүүл ахуйн сургалтуудыг зохион байгуулсан нь хүүхдүүд шүдээ угаах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадалтай боллоо.

Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд “Шүд эрүүл бол бие эрүүл” 3 сарын аяныг зохион байгуулж, эхний 5 байрыг 2.4 сая төгрөгийн үнэ бүхий зүйлээр шагнасан.

БНСУ-ын “Гу үн дентал” компани, Соншим шүдний эмнэлгийн эмч нар Нэгдсэн эмнэлгийн шүдний кабинетад 200,0 сая төгрөгийн өртөг бүхий шүдний иж бүрэн тоног төхөөрөмж хандивласан нь иргэдийн шүдний өвчнийг эмчлэхэд хувь нэмрээ өгч байна.

Нэгдсэн эмнэлэгт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 50.0 сая төгрөгийн өртөг бүхий оношилгоо, шинжилгээ, эмчилгээний тоног төхөөрөмж, 1.0 сая төгрөгийн өртөг бүхий хяналтын монитор, 35.0 сая төгрөгийн яаралтай тусламжийн авто машин, Зоонозын өвчин судлалын төвийн халаалтын тогоог шинэчлэхэд 5.0 сая төгрөг, Булган сумын эрүүл мэндийн төвд хүүхдийн тусламж үйлчилгээг яаралтай үзүүлэхэд шаардлагатай дусал тохируулагч Памп худалдан авахад 3.5 сая төгрөгийн, Эрдэнэбулган сумын 7-р багийн өрхийн эрүүл мэндийн төвийг 15.0 сая төгрөгний өртөг бүхий багаж хэрэгслээр хангаснаар аймаг, сумдын эмнэлгүүдийг нэн шаардлагатай тоног төрөөхөмжийн хангалтыг 84.5 хувьд хүргээд байна.

Явуулын, оршин суугаа хаяг тодорхойгүй, зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг бүртгэлжүүлэн, жирэмсний хяналтын чанар, үр дүн, жирэмсэн эхийн шилжүүлэх тогтолцоог сайжруулж, эх, нярайн хүндрэл эндэгдлийг бууруулах зорилгоор Засаг даргын 2018 оны А/307 дугаар захирамжаар “Орон нутгийн төрөх насны эмэгтэйчүүд, жирэмсэн эхийн нэрийн хяналтыг зохицуулах журам”-ыг батлан аймаг, сум, багийн Засаг дарга, анхан дунд шатны эрүүл мэндийн байгууллагуудын эх, хүүхдэд тавих хяналт, үүргийг тодорхой болгон “Зөвлөлдөх” уулзалтыг зохион байгуулан 1080.0 мянган төгрөгийг зарцууллаа.

Мөн бага насны хүүхдүүдийн суурь өвчнийг эрт илрүүлэн хяналтанд авах, эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөөг батлан, жирэмсний зөвлөгөө өгөх кабинетад эрсдэлт бүлгийн жирэмсэн эхчүүдийг мэргэжлийн эмчээр 100 хувь хянуулах асуудлыг шийдвэрлэсэн.

Эх, нярайд үзүүлэх 2 дахь шатлалын тусламжийг сайжруулахын тулд эх барих, нярайн эмч, эх баригч, нярайн сувилагч нарыг урт, богино хугацааны сургалтанд хамруулж мэргэшүүлэн, яаралтай тусламжийн багаж тоног төхөөрөмжөөр хангасны үр дүнд дутуу төрсөн 24 нярайн 80 хувьд, анхдагч сэхээн амьдруулалт шаардсан нярайн 65 хувьд яаралтай тусламж үзүүлж амь насыг аварсан.

АНУ-ын Денан төслөөс хэрэгжүүлсэн “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ болон олон нийтийн түвшинд эрүүл мэндийн мобайл технологи”-ийг нэвтрүүлэх төслийн хүрээнд Тариат сумын сум дундын эмнэлэгт

28.6 сая төгрөгийн өртөг бүхий түргэн тусламжийн автомашин, тоног төхөөрөмжийг хандивлан, тойргийн 4 сумын эмч нарыг явуулын үзлэг шинжилгээ хийх сургалтанд хамруулан мэргэшүүллээ.

Сумдыг Мобайль технологийн багажаар хангасны үр дүнд “Хэнийг ч орхигдуулахгүй” зарчмыг баримтлан нийт хүн амын 70 гаруй хувийг буюу давхардсан тоогоор 3709 хүнд ЭХО, зүрхний цахилгаан бичлэг зэрэг 10-аад төрлийн үзлэг шинжилгээг хийж, өвчнийг эрт илрүүлэн анхан болон 2 дахь шатлалын эмчилгээнд хамруулан эмчиллээ.

“Элэгний эмгэггүй Архангай-2” төслийн хүрээнд элэгний С вирусын шинжилгээнд 40-64 насны иргэдийн 83.3 хувийг, 15-39 насны иргэдийн 49.8 хувийг, 65-аас дээш насны иргэдийн 49.0 хувийг, В вирусын илрүүлэг шинжилгээнд 40-64 насны иргэдийн 77.2 хувийг, 15-39 насны иргэдийн 49.8 хувийг, 65-аас дээш насны иргэдийн 49.0 хувийг тус тус хамрууллаа.

Төслийн үр дүнд хепатитын В, С вирусын тархалтын түвшинг тогтоож, С вирусын халдвартай иргэдийн 95.0 орчим хувийг үнэгүй эмчилгээнд хамруулан, В вирусын халдварын эсрэг сайн дурын дархлаажуулалтанд 650 хүнийг хамруулан элэлэгний хавдрын 36 тохиолдлыг эрт үед нь илрүүлэн эмчилж байна. Төслийг хэрэгжүүлэхэд ажилласан Нэгдсэн эмнэлгийн эмч, сувилагч, лаборант нарт илүү цагийг хөлсөнд 15.6 сая төгрөг олгож урамшуулснаас гадна, “Элэгний эмгэггүй Архангай -1” төслийн хаалтын ажиллагаа, танилцуулга уулзалтыг УИХ-ын гишүүн, Засгийн газрын төлөөлөл, аймгуудын Засаг дарга, Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтан, эмч нарыг оролцуулан зохион байгуулж 4.9 сая төгрөгийг зарцууллаа.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хотонт, Хашаат сумдын эрүүл мэндийн төв, Эрдэнэмандал сумын сум дундын эмнэлэг, Нэгдсэн эмнэлгийг 91.2 сая төгрөгийн өртөг бүхий түргэн тусламжийн автомашинаар хангаснаар эрүүл мэндийн байгууллагуудын түргэн тусламжийн авто машины хангалтыг 100 хувьд хүргэж иргэдэд яаралтай тусламж, үйлчилгээг шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүллээ.

Засаг дарга, Канад улсын Лаурел сан хоорондын 2022 он хүртлэх хамтын ажиллагааны гэрээний хүрээнд Канад улсын нүдний мэс заслын их эмч ХьюПарсонс болон Клиникийн Нэгдүгээр төв эмнэлгийн нүдний мэс заслын эмч нар Нэгдсэн эмнэлэгт ажиллаж 180 иргэдэд нүдний үзлэг хийж, 91 хүнд сайн дурын үндсэн дээр үнэ төлбөргүйгээр болор солих мэс заслыг амжилттай хийсэн.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Испаниас Европын эвэрхийн нийгэмлэгийн эмч нар Улсын нэгдүгээр төв эмнэлгийн эмч нарын хамтарсан баг ажиллаж 4 хүнд хагалгаа хийсэн ба Австралийн 2 эмч эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслыг 2 хүнд хийлээ. Мөн Эрдэнэмандал сумын сум дундын эмнэлэгт Япон улсын зочин эмч

Курода Кохей ажиллан 158 хүнд шүдний үзлэг, эмчилгээ, сургалт зохион байгуулж, БНСУ-ын Нээлттэй эмч нарын нийгэмлэгийн нарийн мэргэжлийн 42 эмч Батцэнгэл суманд ажиллан тойргийн 4 сумын 1800 гаруй иргэдийг 6 чиглэлээр үзэж, эмээр ханган зөвлөгөө өгсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Цахир сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барихаар суурийг тавьж, Төвшрүүлэх сумын эрүүл мэндийн төвийн барилгын их засварыг 60.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ.

2.2. Боловсролын чиглэлээр:

Сургуулийн өмнөх боловсролд энэ хичээлийн жилд 7368 хүүхэд хамрагдсан нь өмнөх оноос 120 хүүхдээр нэмэгдсэн байна. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 83.2%-тай байгаа нь улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна.

Боловсрол, соёл урлагийн газраас ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын чанарыг үнэлэх ажлыг хичээлийн жилийн эхэнд болон сүүлд зохион байгуулсан бөгөөд бага боловсролын стандарт хангалт нь 2.0%- иар буурч, А, В-ийн эзлэх хувь нь 3.1%-иар өссөн, суурь болон бүрэн дунд боловсролын стандарт хангалт 3.4%-иар, А, В-ийн эзлэх хувь 2.5%-иар өссөн, аймгийн хэмжээнд боловсролын стандарт хангалт нь 0.8%-иар, А, В-ийн эзлэх хувь 3.1 % иар өссөн байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар“Олон улс, тив, дэлхийн зэрэглэлийн тэмцээн, олимпийн наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчид урамшуулал олгох журам”, “Улсын төрөлжсөн олимпиад, элсэлтийн ерөнхий шалгалтанд амжилт гаргасан багш, сурагч, сургуулийг шагнаж урамшуулах журам”-уудыг баталж, тус журмуудын дагуу 15 сурагч, 9 багшийг аймгийн Засаг даргын нөөцөөс 8.8 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа.

2018 оны их дээд сургуулийн элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр Архангай аймаг 13-р байрт орсон нь өмнөх оноос 3 байраар, 2016 оноос 5 байраар урагшилсан үзүүлэлт юм. Өнгөрсөн оноос Орос хэлний хичээлийн дундаж 2, Англи хэлний хичээлийн дундаж 8 пунктээр тус тус өсч, Физик, Монгол хэл, Газарзүй, Биологи, Монголын түүх хичээлийн дундаж улсын дундажаас дээгүүр үнэлгээтэй гарлаа.

“Ирээдүй 1+1” дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвөөс 13.1 сая төгрөгийн Монгол тоглоомын багцыг ерөнхий боловсролын 30 сургууль, 34 цэцэрлэгийн "Ёс заншлын танхим"-д олголоо.

Хүүхдийн урлаг спортын наадмыг урлагийн 7, спортын 6 төрлөөр зохион байгуулж нийт 2500 гаруй хүүхэд багачууд оролцлоо. Лаборатори 1-р сургуулийн багш Ц.Болдбаатар, Спортын төрөлжсөн сургалттай сургуулийн багш Д.Хүрэлбаатар нар шилдэг багшаар, урлагийн наадмын шилдэг сургуулиар Лаборатори 1-р сургууль, Эрдэнэмандал сумын сургууль, шилдэг цэцэрлэгээр

Эрдэнэбулган сумын 2-р цэцэрлэг, Хайрхан сумын цэцэрлэг, Спортын наадмын шилдэг сургуулиар Спортын төрөлжсөн сургалттай сургууль, Хайрхан сумын сургуулиуд тус тус шалгарлаа. Наадамд орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөгийг зарцууллаа.

Архангайн хүүхэд багачуудын уран бүтээлийн “Арын сайхан хангай” үзэсгэлэнг Улаанбаатар хот болон аймагтаа зохион байгуулж сурагчдын авъяас чадвар, бүтээлийг сурталчилсан байна.

“Багшийн хөгжил” дэд хөтөлбөрийн хүрээнд 2, 3, 4 дэхь жилдээ ажиллаж байгаа нийт 142 багшийг орон нутгийн сургалтанд, 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй 288 багшийг үндсэн сургалтанд хамруулж мэргэжил боловсролыг нь дээшлүүллээ.

Орон нутгийн төсвөөс төрийн өмчийн 30 сургууль, 33 цэцэрлэгийн багш нарын ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад 63.0 сая, БСУГ-ын “Багшийн хөгжлийн төв”-ийг шалгалтын хариу засах программ хангамж, автомат цаас татагч бүхий өндөр хурдны скайнераар хангахад 6.0 сая, Өгийнуур сумын сургуулийг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангахад 1.8 сая төгрөгийг тус тус зарцуулж Эрдэнэмандал, Булган, Чулуут, Хангай, Эрдэнэбулган сумын 3, 4-р сургуулиудын “Багш хөгжлийн төв”-ийг орон нутгийн төсвөөс тус бүр нь 4.0 сая нийт 24.0 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжөөр хангаж, багш хөгжлийн танхимыг шинэчлэн байгууллаа.

Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтнүүд сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын нийт 17 судлагдахуун тус бүрээр цахим хаяг нээж багш нарын сайн туршлага, арга зүй, шинэ мэдээллийг солилцож, аймгийн сайн хичээл, хэрэглэгдэхүүний цахим санд 85 мэдээлэл, 21 шилдэг хичээл, даалгаварын санг судлагдахуун тус бүрээр хийж, мэргэжил, арга зүйн зөвөлгөө өгсөн байна.

30 сургууль, 28 цэцэрлэгийн 115 багш оролцсон “Бүтээлч багш”, “Бүтээлч байгууллага” уралдаанд амжилт гаргасан багш, байгууллагыг орон нутгийн төсвийн 15.0 сая төгрөгийн санхүүжилтээр шагнаж урамшууллаа. Тэргүүн байр эзэлсэн 5 багшийг Солонгос улсад мэргэжил дээшлүүлэх эрх, 2, 3-р байруудад шалгарсан 15 багш нарыг өнгөт болон олон үйлдэлт принтрээр тус тус урамшуулсан. “Бүтээлч багш” уралдаанд оролцсон багш нараас 1, 2, 3 болон тусгай байрт шалгарсан 28 багшийн заасан хичээл, хэрэглэгдэхүүнийг аймгийн сайн хичээл, хэрэглэгдэхүүний цахим санд байршуулах ажил хийгдэж байна.

“Бүтээлч байгууллага”-аар Эрдэнэбулган сумын 1, 3-р сургууль, Цэнхэр сумын сургуулиуд, Эрдэнэбулган сумын “Ирээдүй”, 5, 8 дугаар цэцэрлэгүүд тус тус шалгаран сургалтын техник, тоног төхөөрөмжөөр шагнагдав.

Насан туршийн боловсролын төв, түүний нэгжүүдэд гэр бүлийн 93, амьдрах ухааны 81, ёс суртахуун төлөвшил, иргэний боловсролын 125, гоо зүй эрүүл мэндийн 198 удаагийн сургалт зохион байгуулж 13783 иргэнийг хамруулан тэдний сурч боловсрох хэрэгцээг хангасан байна.

14 сургууль, 2 цэцэрлэгт улсын төсөв болон төсөл хөтөлбөрийн 38.6 сая төгрөгийн санхүүжилтээр Багш хөгжлийн танхимд техник тоног төхөөрөмж, дугуйлан секцийн хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай, Эрдэнэбулган сумын “Ирээдүй”, Чулуут, Ихтамир, Өндөр-Улаан, Хангай, Цэнхэр, Өгийнуур сумын сургуулиуд төсөл хөтөлбөр, орон нутгийн хөгжлийн сан, хандив тусламжаар сургалтын тоног төхөөрөмж, Өндөр-Улаан, Тариат, Төвшрүүлэх, Хайрхан, Цэнхэр, Эрдэнэбулган сумын 1, 2, 3 дугаар сургуулиудад БСШУСЯ-ны 40.4 сая төгрөгийн санхүүжилтээр хатуу эдлэл, 7 сургууль 22.9 сая төгрөгөөр дугуйлан, секцийн хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай авсан.

Өгийнуур, Өндөр-Улаан, Өлзийт сумдын сургуулийн дотуур байранд улс орон нутгийн төсөв, хандив тусламжийн 29.7 сая төгрөгийн санхүүжилтээр гал тогооны тоног төхөөрөмж, хатуу, зөөлөн эдлэлийн шинэчлэл хийгдсэн.

Ихтамир сумын цэцэрлэгт орон нутгийн хөгжлийн сангийн 2.0 сая төгрөгийн санхүүжилтээр хөгжмийн зэмсэг, Тайпэн худалдаа эдийн засгийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газраас 25 цэцэрлэгт 12.3 сая төгрөгийн үнэ бүхий гэр цэцэрлэгийн зуухны хаалтыг тус тус нийлүүлж, Өндөр-Улаан, Цэнхэр сумдын хүүхдийн цэцэрлэгт улсын төсөв, хандив тусламжийн 4.4 сая төгрөгийн санхүүжилтээр гал тогооны тоног төхөөрөмж, Эрдэнэбулган сумын 10, 11, 14 дүгээр цэцэрлэгүүд БСШУСЯ-ны 18.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тоглоом наадгай сургалтын тоног төхөөрөмж, гадаах тоглоомын талбай болон биеийн тамирын сургалтын хэрэглэгдэхүүнээ шинэчилсэн байна.

Хотонт сумын цэцэрлэгт БНТУ-ын “ТИКА” агентлагийн буцалтгүй тусламжийн 30.0 сая, Өлзийт сумын цэцэрлэгт Мобиком, ДЗОНХХ, орон нутгийн төсвийн 90.0 сая төгрөгийн санхүүжилтээр тус тус ариун цэврийн байгууламжийг шинээр ашиглалтанд орууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хайрхан сумын 75 хүүхдийн дотуур байранд 232.2 сая, Японы “Өвсний үндэс” хөтөлбөрөөс Тариат сумын 200 хүүхдийн дотуур байранд 207.8 сая, ДЗОУБ, Орон нутаг хөгжлийн сангаас Төвшрүүлэх сумын 100 хүүхдийн дотуур байранд 162.2 сая төгрөгөөр тус тус их засвар хийгдсэн. Жаргалант сумын 75 хүүхдийн дотуур байрыг шинээр ашиглалтанд орууллаа.

Батцэнгэл сумын уурын зууханд улсын төсвийн 25.0 сая, Өндөр-улаан сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн халаалтын шугамд улсын төсвийн 33.0 сая, Эрдэнэбулган сумын 10 дугаар цэцэрлэгийн гал тогооны барилгад 10.0 сая, 4-р

сургуулийн урлагийн заалны дээвэрт 20.0 сая, Эрдэнэмандал сумын сургууль, цэцэрлэгийн халаалтын шугамд 150.0 сая төгрөгөөр тус тус их засвар хийлээ.

Эрдэнэмандал суманд 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажил эхэлсэн. 40%-ийн гүйцэтгэлтэй байна. БНХАУ-ын хөрөнгө оруулалтаар Эрдэнэбулган сумын 7 дугаар багт 100 хүүхдийн цэцэрлэг шинээр баригдахаар суурийн ажил эхэлсэн бөгөөд 2019 оны 9-р сард ашиглалтад орно. Хангай сумын 50 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг цэвдэгтэй холбоотойгоор газар хөлдөхөөр хийхээр хойшлуулсан.

2.3. Соёл, урлагийн чиглэлээр

Соёлын өвийн төв, Үндэсний номын сан, СУИС-ийн сургагч багш нартай хамтран соёлын төвийн эрхлэгч, номын санч, хөгжим, бүжгийн багш нар, соёлын өвийн ажилтнууд, ерөнхий боловсролын сургуулийн номын санч, Хөгжимт драмын театр, Номын сан, Музейн ажилтнууд нийт 110 хүнийг чадавхжуулсан бөгөөд орон нутгийн төсвөөс тус арга хэмжээнд 1.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Ээждээ захидал бичээрэй", Монгол цэргийн өдөр, зэвсэгт хүчний 97 жилийн ойд зориулж "Аавдаа захидал бичээрэй" уралдаануудыг зохион байгуулж нийт 320 гаруй хүн оролцлоо. "Үндэсний бичиг үсгийн баяр-2018" арга хэмжээнд Ихтамир, Цэнхэр, Хайрхан, Өндөр-Улаан, Хашаат, Өлзийт, Хотонт, Цахир, Батцэнгэл, Эрдэнэбулган сумдын 220 хүн хамрагдсан байна. "Номын баяр-2018" арга хэмжээнд Ихтамир, Төвшрүүлэх, Хотонт, Эрдэнэбулган сумын ЕБС-ийн сурагчид болон цэцэрлэгүүдийн бэлтгэл бүлгийн сурагчид, багш ажилчид, номын санчид нийт 600 гаруй хүн хамрагдаж 4 төрлийн уралдаан, зохиолч уншигчдын уулзалт, номын санч нарын болон технологийн багш нарын сургалт, гар урлалын үзэсгэлэнд оролцлоо.

Эрдэнэ мэргэн бандида, ханчин хамбо, онолч эрдэмтэн, Сүрэнхорын Жамъяангаравын нэрэмжит "Хангайн цом" яруу найргийн наадмыг зохион байгуулж нийт 40 яруу найрагч оролцон үгийн урнаар өрсөлдлөө. Наадмын хүрээнд зохиолч, яруу найрагч-уншигчдын уулзалт, Монгол хэл, уран зохиолын багш нар, оюутан сурагчдад зориулсан сургалт хийгдлээ. Яруу найргийн наадмын арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 1.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв.

"Оюунлаг Архангайнхан" эрдэм, шашин, соёлын нэгдсэн арга хэмжээг амжилттай зохион байгуулж, анх удаа "Учиртай гурван толгой" дуурийг хөдөө орон нутгийн үзэгчдэд толилууллаа.

"Эгшиглэнт магнай" хөгжмийн үйлдвэрт 4 шанаган хуурыг хандив тусламжийн 5.0 сая төгрөгөөр хийлгэж авснаар Хөгжимт драмын театрт 11 шанаган хуур бүхий "Шанаган хуурын хамтлаг" байгуулагдаж "Эрдэнийн хэлхээ" шинэ уран бүтээлийн нээлтийн тоглолтоо хийлээ.

Хөгжимт драмын театрын уран бүтээлчид “Энх мэндийн хадаг”, “Эрдэнийн хэлхээ” шинэ уран бүтээлийн тоглолтыг Эрдэнэбулган, Цэнхэр, Ихтамир, Булган сумдын иргэд болон Булган, Орхон, Дархан-Уул аймгууд, Улаанбаатар хотын үзэгч дэд амжилттай тоглож аймаг орон нутгаа сурталчлан 1 хот, 3 аймаг, 3 сумдын нийт 2000 орчим үзэгчдэд соёл урлагаар үйлчилсэн байна.

Улсын төсвийн хөрөнгөөр “Төв Монголын байгаль-түүх-соёлын цогцолбор” байгуулах зураг төсвийг боловсруулсан бөгөөд тус цогцолборын В блокод ажилчдын ажлын байр, фонд байхаар зурагт тусгагдсан байна.

Ихтамир сумын соёлын төвд улсын төсвийн 7.5 сая, Өгийнуур сумын соёлын төвд сум хөгжүүлэх сангийн 5.0 сая, Цэцэрлэг сумын соёлын төвд орон нутгийн төсвөөс 3.0 сая төгрөгийн төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг нийлүүлээ.

Энэ жил Хашаат, Өлзийт, Цэцэрлэг сумдад соёлын төвийн шинэ барилгын ажлын гүйцэтгэгчээр “Хатуу төмөр”, “Саруул цамхаг”, “Баганат өргөө”, “Алтайн бумбат өргөө” ХХК-иуд тус тус шалгарч барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байна.

Орон нутгийн төсвийн 100.3 сая төгрөгийн санхүүжилтээр “Бөх цогцолбор, хүүхэд залуучуудын парк” байгуулах ажлыг эхлүүлж, 12 жилийг солих, хүндэтгэлийн самбар босгох, сагсан бөмбөгийн талбай байгуулах, гэрэлтүүлэг тавих зэрэг ажлуудыг хийгээд байна.

2.4. Биеийн тамир, спортын чиглэлээр:

Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, хүн бүр биеийн тамир, спортоор хичээллэх, байгууллага, хамт олон, өрх гэр бүлд эрүүл амьдралын орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн 78 удаагийн арга хэмжээнд 39021 иргэн хамрагдлаа.

“Алтан шипи” хөнгөн атлетикийн мастеруудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 15 байгууллагын 200 гаруй тамирчид, мөсний шагай, үндэсний бөх, үндэсний сурын харвааны төрлүүдээр зохион байгуулагдсан Үндэсний спортын ҮИ их наадамд 13 сумын 125 тамирчин, Монгол Улсын ерөнхий сайдын нэрэмжит “Иргэний спортын наадам”-д 7 сумын 750 гаруй тамирчид, “Эрүүл Архангай” намрын спартакиадад 6-18 насны 1500 гаруй сурагчид тус тус оролцож авхаалж самбаа, хурд хүчээ сорилоо.

Улсын төсвийн 9.0 сая төгрөгийн санхүүжилтээр Усан бассейнд спортын хэрэглэл болон бусад бараа материалыг аваад байна. Орон нутгийн төсвийн 10.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Цэцэрлэг суманд бөхийн дэвжээ олголоо.

2.5 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр:

Хүн амыг нийгмийн даатгалд хамруулж төрийн үйлчилгээг хүргэх зорилгоор нийгмийн даатгалын тухай хуулийн ач холбогдлыг тайлбарлан таниулах сургалт мэдээллийн ажлыг 19 сумын 10 гаруй багийн иргэдийн нийтийн хурал, 307 аж

ахуйн нэгж байгууллагын хурал, зөвлөгөөний үеэр 3070 гаруй иргэнд мэдээллийг хүргэсний үр дүнд сайн дурын даатгалд 4963 даатгуулагчийг хамруулсан нь хамрагдвал зохих иргэдийн 14.7 хувийг, эрүүл мэндийн даатгалд 11446 даатгуулагчийг буюу 34.1 хувийг хамруулсан байна.

Их дээд сургууль, МСҮТ-д суралцаж байгаа 2300 оюутны 576 суралцагч буюу 25 хувийг эрүүл мэндийн даатгалд хамруулсны үр дүнд залуучуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эмчилгээ, үйлчилгээнд хамруулах нөхцлийг бүрдүүллээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын амралтын барилгын засварын ажлыг 80.0 сая төгрөгөөр засварлах ажлыг 2018 оны 8 дугаар сард ажлыг хийж гүйцэтгэсэн тус ахмадын амралтын газарт 431, магадлан итгэмжлэгдсэн рашаан сувилалд 438 ахмад настан амарч сувилуулсан. Ахмадын зориулалттай амралт сувилалын газарт амарсан 636 ахмад настанд 122.8 сая төгрөгийн хөнгөлөлт тус тус олголоо.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний "Сэргээн засах", "Өдрийн үйлчилгээ" үзүүлэх магадлан итгэмжлэлийн эрх авсан "Нандин хүлэг" ХХК, "ОЧЦО" эрүүл мэндийн төв "Энхийн түүчээ" ХХК, "Хангай мам дацан", аймгийн "Ахмадын хороо" төрийн бус байгууллагуудаар тус тус гэрээлэн гүйцэтгүүлж 118 ахмад настан, 50 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилгээг хүргэлээ.

Аймгийн хэмжээнд зорилтот бүлгийн 513 өрхийг сонгон авч Зорилтот бүлгийн 88 өрхөд Дэлхийн зөн ОУБ-ын санхүүгийн дэмжлэгээр эрх зүй, амьдрах ухаан, эрүүл мэнд, бизнесийн чиглэлээр сургалтуудыг зохион байгуулсан. Нийтийг хамарсан ажилд 26 өрх, төсөл хөтөлбөрт 49 иргэнийг хамруулж байнгын ажлын байртай болсон. Зорилтот өрхийн 391 иргэнийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж 49 иргэнийг эрүүл мэндийн даатгалд, 17 иргэнийг нийгмийн даатгалд шинээр хамруулсан. Мөн 6 өрхийн 6 иргэнийг өөрийн гэсэн өмчлөлийн газартай болгож, баримт бичгийн зөрчилтэй байсан 14 иргэнийг баримт бичгийг баталгаажуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны а/57 дугаар захирамжаар Архангай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийг байгуулан хамтран ажиллах гэрээний дагуу орон нутгийн төсвөөс үйл ажиллагааны зардалд 7.4 сая төгрөг батлан өгсөн. Батлагдсан төсвийн хүрээнд: "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй", хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэмд эзлэх байр суурь, эрүүл мэнд, боловсрол болон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн "Бэлгийн болон нөхөн үржихүйн боловсрол", хөдөлмөр эрхлэлт зэрэг сургалтуудыг тус тус зохион байгуулж 130 хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамруулсан.

Аж ахуй, бичил бизнес болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх замаар ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 35-аас дээш насны 55 иргэнийг хамруулж 165.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож ажлын байр бий болгосон.

71 иргэн, аж ахуйн нэгжид 750.0 сая.төгрөгийн бага хүүтэй жижиг зээлийг олгосны үр дүнд 379 ажлын байр бий болж, үйл ажиллагаа нь тогтворжсон байна.

Төвшрүүлэх, Өлзийт, Булган, Эрдэнэбулган сумдад нийтийг хамарсан ажлыг зохион байгуулан ажилгүй 308 иргэнийг хамруулж, түр ажлын байраар ханган 78.2 сая төгрөгийн цалин хөлсийг олгож, өрхийн орлогыг нь нэмэгдүүлсэн байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг Ихтамир, Чулуут, Хангай, Өндөр-Улаан, Жаргалант, Цэцэрлэг, Эрдэнэмандал, Батцэнгэл, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Булган, Эрдэнэбулган, Цахир, Цэнхэр зэрэг 15 суманд хэрэгжүүлж 65 өрхийг хамруулан малжуулж нийт 300.0 сая.төгрөгөөр богд шилжүүлснээр нийт 2000 гаруй толгой мал худалдан авч өгч залуу малчин өрхийн мал тоо толгойг өсгөн, өрхийн орлогыг нь нэмэгдүүлсэн байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй 17 иргэнд 50.0 сая .төгрөгийн эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгож ажлын байртай болгосон байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу 22 иргэнд 3.8 сая төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламжийг Засаг даргын нөөц сангаас олгосон.

Тамир кино театрын техник тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж, засварлах ажлыг 111.0 сая төгрөгөөр “БМНС” ХХК хандиваар хийж гүйцэтгэж байгаа бөгөөд энэ ондоо багтаан ашиглалтад орно.

ГУРАВ. ТОГТВОРТОЙ НОГООН ХӨГЖИЛ

3.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:

2018 онд Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардалын 478.576.900 төгрөгийг 30 төсөл арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн гүйцэтгээд байна.

Герман-Монголын хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох төслийн санхүүжилтээр манай аймагт хангайн бүсийн судалгаа шинжилгээ, сургалт сурталчилгаа, мэдээллийн төв баригдаж ашиглалтад ороод байна.

Рашааны эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсийг тогтоох ажлыг халуун рашаан болон рашаан төст 5 булгийн бүсийн зургийг гаргаж Цэнхэрийн халуун рашаанд хамгаалалтын бүсийг тогтоон рашааны бүсэд аялал жуулчлалын даац тогтоох судалгааг хийлгээд байна.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Тамирын жавар” өвлийн наадам мөсний баяр, мөсний шагай, Булган ууланд зул өргөх ёслол, Билгийн

тооллын хаврын тэргүүн сарын шинийн 15-ны өдөр “Алтан зуу бурханы их мөргөл”, Орхоны хөндийн бяцхан 99 баатрын аялал, Адуучны баяр зэрэг арга хэмжээнүүд болж нийт 5500 гаруй хүн оролцлоо.

Жуулчдын аюулгүй байдлыг хангах, жуулчдыг үнэн бодит мэдээллээр хангах, Архангай аймагт дахин ирэх сэдлийг төрүүлэх, тав тухтай орчноор үйлчлэх зорилгоор аялал жуулчлалын мэдээллийг нэгтгэн мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулж байна.

“Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаа ба уур амьсгалын өөрчлөлт” сургалтыг сум дундын ойн анги, ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллага, байгаль хамгаалагчид нийт 90 гаруй төлөөллийг хамруулан зохион байгуулалаа. Шинээр байгуулагдсан ойн 6 нөхөрлөлийн 28000 га талбайд ой зохион байгуулалтын ажлыг хийж нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжин ажилалаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэмжлэгээр Өгийнуур суманд 0.9 га талбайг хашиж ойн зурвас байдлаар хамгаалан нийт 1400 ширхэг улиасыг 7 сая төгрөгийн санхүүжилтээр хийж, арчилгаа, усалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Ойн судалгаа хөгжлийн төв, аймгийн Засаг даргын дэргэдэх сум дундын ойн анги, “Гранд форест” ХХК-тай хамтран 700000 гаруй га талбайд судалгааны ажлыг хийж гүйцэтгэснээс 259,000 га талбай голомт илэрч тэмцлийн ажлыг хийлээ.

Улсын төсвийн хөрөнгөөр 5 сумын 25.900 га талбайд тэмцэх ажлыг зохион байгууллаа.

Цэнхэр сумын Орхон багийн алтны уурхайд хууль бус алт олборлолт, байгаль орчны бохирдлоос сэргийлэх зорилгоор байнгын ажиллагаатай хяналтын пост ажиллуулан үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудтай нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлж 37 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 17.4 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг гүйцэтгүүлээд байна.

Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан 2018 онд ойгоос бэлтгэх модны хэмжээнд тулгуурлан талбайн тусгаарлалтын ажлыг 145 га талбайд, Монгол Улсын Засгийн газраас баталсан ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хүрээнд цэвэрлэгээний огтлолтоор 8985 шоо метр хэрэглээний мод, 80000 гаруй шоо метр түлээг бэлтгэлээ.

“Ойн тухай” хууль тогтоомж зөрчсөн 14 иргэний хууль бусаар бэлтгэсэн 51.6842 шоо метр түлээ, хэрэглээний модны экологи-эдийн засгийн үнэлгээг гаргаж холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. Ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтанд 723 иргэн, аж ахуйн нэгж байгууллага, өрх хамрагдаж 18 зөрчил илрүүлэн 5.400.000 төгрөгийн торгууль, 11148687.72 төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж 70 % барагдуулаад байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 6 дугаар сарын 11-ний 33 дугаар тогтоолоор 302 дурсгалт газрын 2999 “Түүх, соёлын үл хөдлөх дурсгал”-ын жагсаалтыг батлуулж, дээрх газруудаар аялах боломжийг бүрдүүллээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Булган уулын чиглэлийн явган аяллын замыг тохижуулах ажлыг хийж, Булган уулын өвөрт цэцэрлэгт хүрээлэн бий болгох зорилгоор тарьсан мод бутны усалгаа арчилгааны ажлыг тогтмол хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий агнуур зохион байгуулалтын ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, судалгаанд үндэслэн агнах боломжтой агнуурын амьтдын нөөц, агнуурын бүсийн хил, ан амьтан хамгаалах менежмент төлөвлөгөөний төслүүдийг хийж гүйцэтгээд байна.

Ойжуулалтын ажлыг 3 суманд 5300 ширхэг улиасны тайрдас, хүлэмжинд 7 кг шинэс, 9 кг шар хуайс, 2 кг хайлаас, 1 кг гүйлс, 200 гр нарсны үрийг тарьж, усалгаа, арчилгааны ажлыг тогтмол хийж гүйцэтгэлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/52 тоот тушаалын дагуу аймгийн Байгаль орчны салбаруудын нэгдсэн “Нээлттэй хаалганы өдөр”-ийг амжилттай зохион байгууллаа.

Тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх сургалтыг 12 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, байгаль хамгаалагч, багийн Засаг дарга нарыг хамруулан зохион байгууллаа.

Тариат сумын ус, цаг уурын шинжилгээний өртөөний барилгыг барьж дуусгаад байна.

ДӨРӨВ.ТОГТВОРТОЙ ЗАСАГЛАЛ

4.1. Тогтвортой хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх чиглэлээр:

Төрийн албаны шинэчлэн батлагдсан хууль 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан тодорхой ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.

2018 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр аймгийн төрийн албаны удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж, 280 гаруй албан хаагчид хамрагдсан. Цаашид энэ зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулахаар төлөвлөөд байна.

2018 онд төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд давхардсан тоогоор 400 гаруй албан хаагчид сургалтад хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн.

2018 оны 9 дүгээр сарын 10-11-ний өдрүүдэд “Бодлогын хэрэгжилтийг үнэлэх арга зүй” сэдэвт 16 цагийн сургалтад агентлагуудын хяналт шинжилгээ, үнэлээ хариуцсан ажилтнууд, аймгийн ЗДТГ-ын мэргэжилтнүүд нийт 33 албан хаагч хамрагдлаа.

Засгийн газрын 01 дүгээр албан даалгавар, Засгийн газрын 258, 138 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2018 оны 8 дугаар сарын 31-ний а/433 дугаар захирамж гаргаж, 434 дүгээр захирамжаар төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн дарга, захиралын сахилга хариуцлагын журам баталж мөрдүүлээд байна. Дээрх шийдвэрүүдийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор ажлын хэсэг байгуулж, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 23 агентлаг, 18 сум 85 байгууллагад шалгалтыг зохион байгууллаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор Багийн хөгжлийн аймгийн дэд хөтөлбөрийг батлуулж, 27 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Багийн хөгжлийн аймгийн дэд хөтөлбөрийг хүрээнд багийн Засаг дарга нарыг унаажуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөж, 2018 онд Багийн Засаг дарга нарын дунд болзолт уралдаан зарлаж эхний байрт шалгарсан Засаг дарга нарыг унаажуулж, техник хэрэгслээр хангах ажил энэ ондоо багтаан хийгдэх юм.

2018 онд Батцэнгэл, Цэнхэр, Төвшрүүлэх, Цахир, Эрдэнэбулган сумын 1, 2 дугаар багууд орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинэ багийн төвтэй боллоо.

Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг түргэн шуурхай болгох ажлын хүрээнд Эрдэнэбулган суманд 2 ширхэг төрийн үйлчилгээний цахим машин /ТҮЦ/ байрлаж, иргэд 18 төрлийн 2891 удаагийн үйлчилгээ авсан байна.

Төрийн байгууллагуудын өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах зорилгоор "Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам"-ыг шинэчлэн баталж бүх төрийн байгууллагуудад мөрдүүлсний зэрэгцээ, 2018 оны 4 дүгээр сарын 13-нд сумдын архив, бичиг хэргийн эрхлэгч нарын сургалтыг зохион байгуулж, гарын авлагаар хангалаа.

2018 онд Засгийн газрын иргэд хүлээн авах төв 11-11-д Архангай аймгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 15 иргэн хандаж, хариу өгч, аймгийн 70331111 нээлттэй утсанд иргэдээс ирсэн хүсэлтийг тухай бүрт нь шийдвэрлэсэн.

Аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсээс "Архангай Аялал жуучлал-2018" уулзалт хэлэлцүүлгийг төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, байгаль орчин, аялал жуулчны стандартын талаар мэдээлэл хийж, боршур гарын авлагаар хангасан.

Дэлхийн стандарт Монголд аяны хүрээнд Олон улсын баталгаажуулалтын байгууллагын "Мон Сертф" ХХК-тай хамтран ISO 9001:2015 стандартын танилцуулах сургалтыг зохион байгуулж, 60 гаруй иргэнийг хамрууллаа.

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн Мэргэшсэн нягтлан бодогчдын холбооноос зохион байгуулсан няравын ахисан шатны сургалтад MNS 5364:2011 Худалдааны агуулахын стандарт болон төмс хүнсний ногоо болон хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын стандартаар 150 гаруй хүнд 3 удаа сургалт мэдээлэл хийлээ.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамруулах зорилгоор 2018 онд 10 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан байна.

Аймгийн хэмжээнд тохиолдож болзошгүй байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр буюу газар хөдлөлт, ой хээрийн түймэр, объектын гал түймрийн төрлүүдээр эрсдэлийн үнэлгээ хийгдсэн.

Тайлангийн хугацаанд цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх багц мессежийг 17 удаа 19 сумын 38397 иргэнд, мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх багц мессежийг 3 удаа 8 сумын 8805 малчин өрхөд хүргэжээ.

Жаргалант, Эрдэнэмандал, Тариат суманд Гамшгаас хамгаалах команд штабын сургууль хийж сумын онцгой комисс, штаб, мэргэжлийн анги нийт 318 хүний бүрэлдэхүүн хамрагдлаа. Тус сургалтаар гамшгаас хамгаалах талаар хууль дүрэм журмаар танхимын хичээл орж, зам тээврийн осол, газар хөдлөлтийн үед эрэн хайх аврах ажиллагааны дадлага сургууль хийж, удирдах бүрэлдэхүүний дунд сорил тэмцээн явуулж сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсрууллаа.

Шүлхий өвчин гарсан 7 суманд хорио цээрийн дэглэм тогтоон, төв штаб байгуулагдан 37 хяналтын постыг ажиллуулж, 14 голомтын 32 өрхийн шүлхий өвчнөөр өвчилсөн 1.6 сая толгой малыг вакцинжуулж, хорогдсон малын сэг зэмийг, булшлах ажлыг зохион байгуулж 500 гаруй албан хаагч, 138 техник хэрэгслийг дайчлан ажиллуулсан.

Архангай аймгийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулж, аймаг орон нутаг, 12 алба, 19 мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдал хангагдсан байна.

Аймгийн Онцгой байдлын газарт гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв байгуулах, техник хэрэгслийг орон нутгийн төсвөөс 26.0 сая төгрөгийг шийдвэрлэж, Онцгой байдлын ерөнхий газар болон 21 аймагтай цахимаар холбогдож мэдээ мэдээллийг дамжуулан ажиллаж байна.

4.2. Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр:

Цагдаагийн газартай хамтран Хангайн бүсийн аймгуудын цагдаагийн газрын удирдлага, чиглэл хариуцсан ахлах, алба хаагчдыг оролцуулан “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг”, “Мал хулгайлах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид анхаарах асуудал” сэдэвт зөвлөгөөн, Батцэнгэл суманд “Мал

хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд иргэдийн оролцоо” сэдэвт яриа таниулгыг Хотонт, Төвшрүүлэх, Өгийнуур, Өлзийт, Цэнхэр сумдын иргэд, малчдыг хамруулан тус тус амжилттай зохион байгууллаа.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 44,9 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн Эрдэнэбулган сумын авто замын уулзваруудыг камержуулж, сервер төхөөрөмжийг цагдаагийн газарт төвлөрүүлэн ажиллаж байна. Мөн “Сэрэмжилье-Нэгдье” арга хэмжээний хүрээнд 71 аж ахуй нэгж, байгууллага, дэлгүүрүүдэд шинээр хяналтын камерыг байршууллаа.

“Хяналт шалгалт хийх ажлын удирдамж”-ын хүрээнд 2018 оны 6 дугаар сарын 17-21-ний өдрүүдэд аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг банк, шатахуун түгээх станц, ломбард, баар, ресторан, буудал, томоохон үйлчилгээний төв, зах зэрэг нийт 52 газрын камержуулалтыг шалгаж, шаардлага хангахгүй камер байршуулсан 36 газарт албан мэдэгдлийг хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцон албан мэдэгдлийн мөрөөр 32 газрын камержуулалт, гэрэлтүүлгийг сайжруулан ажилласан байна.

Түүнчлэн орон нутагт үйлдэгдэж буй орон байрны болон мотоциклын хулгай, гудамж талбайд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, бусад төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Эрдэнэмандал, Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан сумдын төвийг бүрэн камержуулах ажил явагдаж байна.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийг илрүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр “Хяналт” хэсэгчилсэн арга хэмжээг 30 хоногийн хугацаатай зохион байгуулж Мал, махны гарал үүслийн тодорхойлолтын загварыг шинэчлэн гаргаж 8 суманд туршилтын журмаар хэрэглэхээр багийн дарга нартай хамтран ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагууд чиг үүргийн хүрээнд нэгдэн Монгол Улсын хэмжээнд архидан согтуурахыг бууруулах, түүний хор уршгийг таниулах, согтуугаар үйлдэгдэх гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн “Сар шинэ”, “Хуулиа мөрдье-21”, “Хуулийн хэрэгжилт” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд согтуугаар үйлдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.58 хувиар буурчээ.

Тус арга хэмжээний хүрээнд 382 аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд 12 удаагийн хяналт шалгалтыг хийж, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр 64 аж ахуй нэгжид албан мэдэгдэл, 8 дэлгүүрт шаардлага хүргүүлж, хариу авч, үр дүнг тооцон ажилласан.

Хууль, эрх зүйн хэлтсээс тус аймаг дахь Монгол банктай хамтран “Банкны хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах” чиглэлээр 1-6 дугаар сард 6 удаагийн аян зохион байгуулж, ажиллалаа.

Олон улсын хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах өдрийг тохиолдуулан ХААН, ХАС, Капитал, Төрийн банкны хэрэглэгч нарт “Банкны бүтээгдэхүүн”, “Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан хууль тогтоомж”, “Цахим гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх”, “Санхүүгийн хэрэглэгчийн Төлбөрийн карт, түүний зохистой хэрэглээ” зэрэг цогц асуудлын хүрээнд иргэдэд мэдээлэл, сургалтыг хийлээ.

Орон нутгийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, осол аваар, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүднээс Цагаан давааны замд ослын зогсолтын зурвасын засвар үйлчилгээг сэргээж хөдөлгөөнд оролцогч жолооч нарт анхааруулах үүднээс “Аюултай хэсэг” бүхий анхааруулах самбар 2-ыг, Хархорин-Цэцэрлэг чиглэлийн А0602 замын тэмдэг, тэмдэглэгээг стандартад нийцэж байгаа эсэх, цаашид хийх шаардлагатай тэмдэг, тэмдэглэлийг орон нутгийн төсвөөс 400 метр хайс, 1200 метр хашлага, 400 метр кв зогсоолын хөрөнгийг шийдвэрлэн ашиглалтад оруулан, мөн зам тээврийн яамны авто замын хөгжлийн сангаас А0601 замд 47 ширхэг, А0602 замд 115 ширхэг, А0603 замд 215 ширхэг, А027 замд 14 ширхэг тэмдгүүдийг стандартын дагуу хийж гүйцэтгэсэн байна.

Улсын бүртгэлийн эд хөрөнгийн тасаг нь 2018 оны 11 дүгээр сарын байдлаар хуулийн этгээдээс 6020 мэдүүлгийг хүлээн авч үйлчилгээ үзүүлжээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 1480 ширхэг цаасан хувийн хэрэг материалыг цахимжуулах ажил 2018 оны 11 дүгээр сараас эхэлсэн бөгөөд 600 ширхэг хувийн хэргийг цахимжуулж, ажлын гүйцэтгэл 40.5 хувьтай байна.

Мөн архивын 32 хөмрөгийн баримтыг цахимд санд оруулж, цахимжуулах ажил 22 хувьтай явагдаж байна.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс гэмт хэрэг зөрчлийн тоон үзүүлэлтэд үндэслэн энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэл бүхий нийтийн албан тушаалтнуудад Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх хэлтэс болон аймгийн Прокурорын газартай хамтран 450 гаруй төрийн албан хаагч, 120 иргэнд “Авлига, ашиг сонирхлын зөрчлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл” сэдвийн хүрээнд сургалтыг зохион байгуулав.

4.3. Батлан хамгаалах салбарын чиглэлээр:

Монгол Улсын батлан хамгаалах үйл ажиллагааг сурталчлах ажиллагааны хүрээнд боловсролын байгууллагатай хамтран Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний анги байгууллагуудын удирдлагууд болон анги салбарууд ирж үзүүлэх тоглолтууд, ард иргэдэд цэргийн алба хаасан архивын лавлагаа үнэ төлбөргүй гарган үйлчиллээ.

Аймгийн 7 суманд гарсан мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний хяналтын постонд 2 ээлжээр тус тус 14 хоногийн хугацаанд цэргийн албыг дүйцүүлэн хааж буй 48 иргэд ажиллалаа.

Зэвсэгт хүчний 256 дугаар ангийг түшиглэн Сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Эрдэнэбулган сумаас 1-р зэргийн бэлтгэл үүрэгтэн 15 хүнийг татан оролцуулж 10 хоногын сургалтыг зохион байгуулж явуулсан.

Тус аймгаас оюутан цэрэг хөтөлбөрт багшийн сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 16 оюутан хамрагдаж Баянхонгор аймаг дахь Зэвсэгт хүчний 339 дүгээр ангид зохион байгуулагдсан цэргийн бэлтгэл сургалтанд 2 сарын хугацаатай, орон нутагт биеэр дүйцүүлэн алба хааж буй 18 иргэнтэй Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн материаллаг баазыг түшиглэн 10 хоногийн хугацаатай цэргийн бэлтгэл сургалтыг тус тус явуулсан.

4.4. Гадаад харилцааны чиглэлээр:

2018 оны 03 сарын 05-08-ны өдрүүдэд Япон улсын Хёго мужид зохион байгуулагдсан Гамшгаас урьдчилан сэргийлэх хорооны 16 дугаар хуралд 2 албан хаагч оролцож туршлага судалсан.

Япон улсаас Монгол улсад суух Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Масато Такаока Архангай аймагт 2018 оны 3 дугаар сарын 19-ний өдөр хүрэлцэн ирж Япон улсын буцалтгүй тусламжийн “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах” хөтөлбөрийн хүрээнд Архангай аймгийн Тариат сумын бүрэн дунд сургуулийн дотуур байрны засварыг хийх санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд засварын ажил хийгдэж дууссан байна.

Архангай аймгийн Засаг даргын Тамгын газрын урилгаар БНХАУ-ын Юньнань мужийн Ардын засгийн ордны зөвлөх, БНХАУ-ын олон улсын худалдааг дэмжих нийгэмлэгийн Юньнань дахь салбарын дарга тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Уулзалтын хүрээнд 6 дугаар сарын 14-20-ны хооронд Юньнань мужид зохион байгуулагдах 5 дахь удаагийн “China-south asia exposition” болон 25 дахь удаагийн “China kunming import & export fair” үзэсгэлэн худалдаанд Архангай аймгийн үйлдвэрлэгчид нэрийн бүтээгдэхүүнээр оролцох боломж нээгдсэн.

Монакогийн Хант Улсын Гадаад хэрэг, хамтын ажиллагааны дэд сайд хатагтай Изабель Розабрунеттог болон Монакогийн Гадаад харилцааны яамны олон улсын төсөл хөтөлбөрийн газрын ажилтан хатагтай Софи Робин нар Архангай аймагт 2018 оны 7 дугаар сарын 08-11-ний өдрүүдэд ажлын айлчлал хийлээ. Айлчлалын хүрээнд Монако улсын буцалтгүй тусламжаар хийгдсэн Музейн зүүн сэмчингийн засвар, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаатай танилцан зарим сумдад ажилласан.

БНСУ-ын Гёнсанбүг мужийн Пухан хотын Хан Дун их сургуульд Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбооноос зохион байгуулсан “Зүүн Хойд Азийн Залуу удирдагч форум-2018” арга хэмжээнд Архангай аймгийг төлөөлөн Өлзийсайханы Авирмэд оролцон “Зүүн Хойд Азийн ирээдүй ба энтрепренершип” сэдвээр илтгэл тавьж 2 дугаар байр эзэлсэн амжилттай оролцсон.

Цэцэрлэг хот болон АНУ-ын Бэлингхэм хот хооронд эгч дүүс хотуудын захирагч нарын дээд хэмжээний уулзалтанд Цэцэрлэг хотын захирагч Ж.Гурвантамир 2018 оны 9 дүгээр сарын 03-07-ны хооронд оролцож дээд боловсролын коллеж болон их, дээд сургуулиудыг эгч дүүс 8 хотын хооронд нь холбох “Эрдэм шинжилгээний түншлэл”-ийн талаар санал тавьж, эгч дүүс хотуудын харилцаагаа улам бүр өргөжүүлсэн.

Бүгд найрамдах Энэтхэг улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Суреш Бабу аймгийн аймгийн удирдлагуудтай уулзаж, үер, усны улмаас учирсан хохирлыг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд Энэтхэгийн Засгийн газраас 20 сая төгрөгийн тусламж үзүүлсэн. Мөн аймгийн англи хэлний 10 багшийг мэргэжил дээшлүүлэх сургалтад үнэ төлбөргүй хамруулах болсон. Тайвань улсад 20 багшийг мэргэжил дээшлүүлэх сургалтад, 20 сурагчийг барилгын инженер мэргэжлээр сургахаар гэрээ хэлэлцээр хийгдсэн.

Эрхэм Төлөөлөгчид өө !

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2026, сум, агентлаг, иргэд, хувийн хэвшлийн саналыг үндэслэн 4 бодлого 15 чиглэл, 120 зорилтын хүрээнд 190 арга хэмжээг төлөвлөсөн.

Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн зорилтыг та бүхэнд илтгэн танилцуулж байна.

НЭГ.ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

1.1. Үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр:

1.1.1. “Архангай түншлэл-2019” үзэсгэлэн худалдаа, “Намрын ногоон өдрүүд”, “Архангайд үйлдвэрлэв” цагаан сар үзэсгэлэн худалдааг зохион байгуулна.

1.1.2. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран зориулалтын бус саванд хүнсний түүхий эд бүтээгдэхүүн хадгалах, тээвэрлэх, хор уршгийн талаар сургалт мэдээллийг шат дараатай зохион байгуулж, хэрэглээг бууруулна.

1.1.3. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжин ажлын байрыг нэмэгдүүлнэ.

1.1.4. “Архангайд үйлдвэрлэв” худалдааны төвийн үйл ажиллагааг жигдрүүлж, орон нутгийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг зах зээлд сурталчлан таниулж, борлуулалтын орлогыг нэмэгдүүлнэ.

1.1.5. “Архангайд үйлдвэрлэв” худалдааны төвд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд туслах зөвлөгөө, мэдээлэл, сургалтын үйлчилгээ үзүүлэх бизнес инкубатор төвийг байгуулна.

1.1.6. “Өрх бүр үйлдвэрлэгч” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.1.7. “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийн хүрээнд махны үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл, менежментийн төлөвлөгөөг боловсруулж, газрын асуудлыг шийдвэрлэнэ.

1.1.8. Аймгийн төвд баригдаж буй ноосны үйлдвэрийн үйл ажиллагааг жигдрүүлж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.1.9. Аймгийн брэнд бүтээгдэхүүнийг стандарт шаардлагад нийцсэнийг тодорхойлсон тохирлын гэрчилгээтэй болгох ажлыг зохион байгуулна.

1.2. Хөдөө аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр:

1.2.1. Төв суурин газрыг түшиглэн гахай, тахианы аж ахуй, өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн фермерийн аж ахуйг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжинэ.

1.2.2. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээнд биотехнологийн ололтыг нэвтрүүлэн, малын генетик нөөцийг ашиглах, хамгаалах ажлыг зохион байгуулж, үржлийн малд үзлэг ангилалт, хянан магадалгаа хийж баталгаажуулна.

1.2.3. Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулж, бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмыг боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.2.4. Хөдөөгийн хүн ам, мал сүрэг, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.

1.2.5. Аймгийн мал эмнэлгийн газрын үйл ажиллагааг дэмжин, мал эмнэлгийн лабораторыг итгэмжлэлд хамруулна.

1.2.6. Гоц халдварт, халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлнэ.

1.2.7. Сумдыг мал угаалгын ваннтай болгох ажлыг шат дараатай зохион байгуулна.

1.2.8. Энгийн болон иж бүрэн цогцолбор хүлэмж байгуулах төслийг хэрэгжүүлнэ.

1.2.9. Эрдэнэбулган суманд төмс, хүнсний ногоо хадгалах автомат зоорь байгуулах санал санаачилгыг дэмжинэ.

1.2.10. Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлж малчид, тариаланчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд шаардлагатай тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгоно.

1.3. Барилга, дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр:

1.3.1. Дулааны станц байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, Цэцэрлэг хотын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллана.

1.3.2. Цэцэрлэг хотод дэвшилтэт технологи бүхий цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулна.

1.3.3. Эрдэнэбулган сумын “Булганхангай” хорооллын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлнэ.

1.3.4. Аймгийн төвийн хуучин барилга, хорооллын дахин төлөвлөлтийг үргэлжлүүлнэ.

1.3.5. Цэцэрлэгт хүрээлэн, гудамж талбай, орон сууцнуудын гадна фасад, зам, тоглоомын талбайг тохижуулж хотын өнгө үзэмжийг сайжруулна.

1.3.6. “Гэрлэх ёслолын ордон” барина.

1.3.7. Аймаг, сумдын газар зохион байгуулалтын болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулна.

1.3.8. Төрийн суурь үйлчилгээний барилга байгууламжуудыг шинээр барьж, байгуулах, өргөтгөл, их засварын ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ.

1.3.9. Аймаг, сумдын төвийн гудамжны гэрэлтүүлгийг цахилгаан зарцуулалт багатай, сэргээгдэх эрчим хүч ашиглан шийдвэрлэнэ.

1.3.10. Өлзийт-Хайрхан-Хөвсгөл чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьж байгуулах ажлыг үргэлжлүүлж, Төвшрүүлэх сумыг Хархорин-Цэцэрлэг чиглэлийн төв замтай 8.5 км хатуу хучилттай авто замаар холбон, аймаг, сумын төв доторх авто зам, даваа гүүрний засвар арчлалтын ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.3.11. Тариат, Хангай суманд хайрган хучилттай авто зам, Хангай сумын ухаа гүвээний гол, Эрдэнэмандал сумын Хануйн гол төмөр бетонон гүүр, Цэцэрлэг сумын зуслангийн гол дээр модон гүүр барина.

1.3.12. Барилга байгууламжийн дулаан алдагдлыг бууруулах чиглэлээр судалгаа хийнэ.

1.3.13. Аймаг, орон нутгийн хөгжилд шаардлагатай төсөл хөтөлбөрүүдэд техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулна.

1.3.14. Эрчим 2 төслийн хүрээнд Цэцэрлэг хотод 10/0.4 кв-ын дэд өртөө байгуулж, 0.4 кв-ын шугамыг шинэчлэн айл өрхөд ухаалаг тоолуур нэвтрүүлэх ажлыг дуусгана.

1.4. Санхүү, төсөв, өмчийн харилцаа, худалдан авах ажиллагааны чиглэлээр:

1.4.1. Аймгийн орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлтийг жигд ханган биелүүлэх, татвар хураалт, хяналтад мэдээллийн технологийг түлхүү ашиглаж, татварын бааз суурийг тэлэн татвар төлөгч бүрт хүрсэн татварын цогц үйлчилгээг хэрэгжүүлнэ.

1.4.2. Орон нутгийн төсвийн тэнцвэрт байдлыг хангаж, төсвийн зарцуулалтыг хөтөлбөрт суурилсан арга хэмжээний бодит үр дүнд тулгуурлан санхүүжүүлэх бодлого баримтална.

1.4.3. Төсвийн сахилга, хариуцлагыг сайжруулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албаны үйл ажиллагааг бэхжүүлнэ.

1.4.4. Төрийн сангийн төлбөр тооцооны үйлчилгээний чирэгдэлгүй, хөнгөн шуурхай, соёлтой харилцааг сайжруулна.

1.4.5. Орон нутгийн өмчийн ашиглалт, хяналтыг сайжруулж үр ашгийг нэмэгдүүлнэ.

1.4.6. Орон нутагт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр арга хэмжээний тендер шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож “Шилэн тендер шалгаруулалт”-ын бодлогыг хэрэгжүүлнэ.

ХОЁР.ТОГТВОРТОЙ НИЙГМИЙН ХӨГЖИЛ

2.1. Эрүүл мэндийн чиглэлээр:

2.1.1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хэнийг ч орхигдуулахгүй хамруулна.

2.1.2. Алслагдсан нутгийн иргэд, отроор яваа малчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.1.3. Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй, чанартай үзүүлж, эхийн эндэгдэлгүй ажиллан, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1000 амьд төрөлтөнд 27.0 промилль болгон бууруулна.

2.1.4. Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх замаар өвчлөлөөс урьдчилан сэргийлэх эрүүл зан үйлийг төлөвшүүлнэ.

2.1.5. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг чадавхижуулан, барилга, тоног төхөөрөмж, санхүү, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ээлтэй байдлыг хангана.

2.1.6. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн тогтолцоог бэхжүүлж түргэн тусламжийн автомашины хангалтыг нэмэгдүүлнэ.

2.1.7. Нэгдсэн эмнэлгийн барилгад их засвар хийж, эмчилгээ үйлчилгээний ээлтэй байдлыг хангана.

2.2. Боловсролын чиглэлээр:

2.2.1. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 84.0%-д, бага, суурь боловсролын хамран сургалтыг 94.0%-д хүргэнэ.

2.2.2. Боловсролын чанарын болон суралцагчийн мэдлэг чадвар, төлөвшлийг үнэлэх шинэ журмыг хэрэгжүүлэн, багшийн ажлыг сурагч бүрийн сурлагын ахиц, амжилтаар үнэлэх ажлыг зохион байгуулна.

2.2.3. “Ирээдүй 1+1” хөтөлбөр хэрэгжүүлж, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүдийг урлаг спортын дугуйлан секцэнд хамруулан, хүүхдийн урлаг спортын наадам зохион байгуулж, дугуйлан секцийг шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангана.

2.2.4. “Багшийн хөгжил” хөтөлбөр хэрэгжүүлж, ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн багш нарын мэргэжил боловсролыг дээшлүүлэн, сургууль, цэцэрлэгийн багш хөгжлийн танхимыг техник тоног төхөөрөмжөөр хангах ажлыг шат дараатай зохион байгуулна.

2.2.5. Багш нарын мэргэжил боловсролыг гадаад улс орнуудад дээшлүүлнэ.

2.2.6. Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийг хатуу, зөөлөн эдлэл, техник тоног төхөөрөмж, тоглоом наадгайгаар хангана.

2.2.7. Сургууль, цэцэрлэг, дотуур байрын барилга, өргөтгөл шинээр барьж, багш сурагчдын ажиллах сурч хөгжих орчин бүрдүүлнэ.

2.2.8. Цэцэрлэгийн гадна тоглоомын талбай байгуулж, тоглоом наадгайгаар хангана.

2.3.Соёл, урлагийн чиглэлээр:

2.3.1. Мэргэжлийн урлагийн байгууллагын шинэ болон шинэчилсэн уран бүтээлийг иргэд, хүүхэд багачуудад хүргэж, уран бүтээлчдийг чадавхижуулна.

2.3.2. Хүүхэд бүрийг уншигч болгох, ном унших дадлыг хөгжүүлэх, үндэсний бичиг үсгийн өв соёлоо дээдлэх, монгол хэл бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хүн амд мэдээлэл, соёлын үйлчилгээг хүргэх олон талт ажлыг зохион байгуулна.

2.3.3. Цахим номын сангийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

2.3.4. Соёлын өвийг хамгаалах, хадгалах ажлыг зохион байгуулна.

2.3.5. Музейн сан хөмрөгийн улсын тооллого зохион байгуулна.

2.3.6. Соёлын төвүүдийн барилга шинээр барих, их засвар хийж, техник тоног төхөөрөмжийг шат дараатай шинэчлэх ажлыг зохион байгуулна.

2.3.7. Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн байгуулна.

2.4.Биеийн тамир, спортын чиглэлээр:

2.4.1. Иргэдийн өдөр бүр идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, тэмцээн уралдаанд оролцох идэвхийг өрнүүлэх арга хэмжээг дэмжиж ажиллана.

2.4.2. Азийн хүүхдийн их наадамд оролцох тамирчдыг бэлтгэнэ.

2.5.Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр:

2.5.1. Малчид, ажилгүй иргэд, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана.

2.5.2. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх ажлыг зохион байгуулна.

2.5.3. Ахмад настны асаргаа үйлчилгээг сайжруулж, ахмадын зориулалттай амралт, рашаан сувилалд хөнгөлөлттэй үнээр амрааж тэдэнд чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээг нэмэгдүүлнэ.

2.5.4. Шивэрт ахмадын амралт сувиллын газрыг тохижуулж ахмадуудын ая тухтай амрах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.5.5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийг оновчтой тодорхойлж, тэдгээр өрхийн гишүүдийн эрэлт, хэрэгцээ, санаачилга, боломжид тулгуурлан боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт зэрэг үйлчилгээг багцлан хүргэж амьжиргааны түвшинг нь дээшлүүлнэ.

2.5.6. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төв”-ийг байгуулан иргэдийг чадавхижуулах, мэргэшүүлэх, сувилах зэрэг цогц үйлчилгээг хүргэнэ.

2.5.7. Бүтээмжтэй, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдлыг хөхүүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэн, бичил, жижиг дунд бизнесийг дэмжих замаар 1500-оос доошгүй шинэ ажлын байр бий болгож, ажилгүйдлийн түвшинг бууруулна.

2.5.8. Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл хоршоо байгуулах 150-аас доошгүй иргэнийг аж ахуй, бизнес эрхлэх арга барилд сурган, санхүү, жижиг зээлийн бодлогоор дэмжин хамтран ажиллана.

2.5.9. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсан иргэний бараа бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлж, ажлын байрны түрээсийн хөнгөлөлт үзүүлнэ.

2.5.10. Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, ногоон байгууламжийг сэргээх, хог хаягдал цэвэрлэх, дэд бүтцийг сайжруулах ажилд иргэдийг хамруулж, түр ажлын байр бий болгож, орлогыг нэмэгдүүлнэ.

2.5.11. Малчид, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

2.5.12. Өрхийн мэдээллийн цахим сан бий болгоно.

2.6. Гэр бүл, хүүхэд залуучуудын чиглэлээр:

2.6.1. Хүүхэд бүрт ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлж, тэднийг болзошгүй эрсдэл, дарамт хүчирхийллээс хамгаалах, нийгэмшүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, байгууллага хамт олон, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.6.2. “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн болон хүүхдийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ

2.6.3. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдын “Түр хамгаалах байр”-ыг ашиглалтад оруулж үйл ажиллагааг эхлүүлнэ.

2.6.4. Тамир кино театрын үйл ажиллагааг тогтмолжуулж хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

ГУРАВ. ТОГТВОРТОЙ НОГООН ХӨГЖИЛ:

3.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:

3.1.1. Орон нутгийн онцлог, давуу тал, иргэдийн ёс заншил ахуй амьдралд түшиглэсэн Булган уулын-буман зул, Тамирын голын-Мөсөн шагай, Сарлаг фестиваль, 99 баатарын аялал, адуучны баяр зэрэг эвэнт арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулна.

3.1.2. “Аялал жуулчлал мэдээллийн төв”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж, мэдээллийн санг шинэчлэн мэдээллийн бааз байгуулна.

3.1.3. Олон улсын жишигт нийцсэн стандартын шаардлага хангасан зочид буудал, жуулчны баазуудыг өргөтгөх, шинээр байгуулах санал санаачилгыг дэмжиж ажиллана.

3.1.4. Орон нутгийн түүх соёлын дурсгалт газруудад түшиглэсэн “Соёлын аялал жуулчлал”-ыг хөгжүүлнэ.

3.1.5. Бэлчээрийг эзэмших, ашиглах, ой мод, самар, жимс, байгалийн дагалдах бүтээгдэхүүнийг хамгаалах, ашиглах асуудлыг шийдвэрлэхэд нутгийн иргэд, ойн нөхөрлөл, малчдын бүлэг, хоршооны оролцоог нэмэгдүүлж, дэмжлэг үзүүлэн мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

3.5.6. “Миний нутаг-миний бахархал” аян өрнүүлж өсвөр үеийг төрөлх аймаг, сумаараа бахархах сэтгэлгээг төлөвшүүлнэ.

3.5.7. Ойжуулалт, ойн арга хэмжээг зохион байгуулж, ойн хөнөөлт шавжийн тархалтын судалгааг явуулж, өвчний голомт бүхий ойн санд тэмцлийн ажлыг цаг алдалгүй авч хэрэгжүүлнэ.

3.5.8. Цөлжилттэй бүсэд мод, бут тариалах, ойн зурвас байгуулах аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжин урамшуулна.

3.5.9. Булган уул орчмын тохижилтын ажлыг үргэлжлүүлэн хамгаалалтыг сайжруулж аялал жуулчлалыг хөгжүүлж, иргэдийн амрах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

3.5.10. Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлж, лиценз эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн хариуцлагыг өндөржүүлэн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг стандартын шаардлагын түвшинд хийлгэх ажлыг зохион байгуулна.

3.5.11. Аймгийн төв болон сумын төвүүдэд шинээр ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, дасан зохицох чадвар бүхий тарьц, суулгацыг шат дараалалтайгаар тарьж ургуулна.

3.5.12. Судалгаанд үндэслэн хуурайшилт ихээр явагдаж байгаа газар хөв цөөрөм байгуулна.

3.5.13. “Заяын хүрээ” Цэцэрлэг хотын аяллын маршрут гаргана.

3.5.14. Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрыг иргэдийн оролцоотой хамгаалах, нөхөн сэргээх зүй зохистой ашиглах ажлыг зохион байгуулж нутгийн иргэд, нөхөрлөлийг чадваржуулах үйл ажиллагааг дэмжинэ.

3.5.15. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг зохион байгуулна.

3.5.16. Өгий нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалж урсацыг сайжруулна.

ДӨРӨВ.ТОГТВОРТОЙ ЗАСАГЛАЛ

4.1. Тогтвортой хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх чиглэлээр:

4.1.1. Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлж, төрийн албаны тухай шинэ хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллана.

4.1.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төрийн албан хаагчийн орон сууц барьж байгуулах төслийг дэмжинэ.

4.1.3. Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг төрийн захиргааны анхан шатны нэгж багийн төвүүдийг бэхжүүлэх “Багийн хөгжлийн дэд хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.1.4. Зөвлөлдөх ардчилал иргэдийн оролцоог дэмжих “Ардын засаглал” хөтөлбөрийн хүрээнд шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, “Иргэний танхим”-ын үйл ажиллагааг сайжруулна.

4.1.5. Явуулын нэг цонхны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, алслагдсан багийн иргэдэд төрийн үйлчилгээг хүргэнэ.

4.2. Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр:

4.2.1. Улсын бүртгэлийн хэлтсийн архивыг цахимжуулж, газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн санг бий болгоно.

4.2.2. Гэмт хэрэгтэй тэмцэх нийтийн хэв журмыг хамгаалах цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг тавих үүрэг бүхий иргэний зөвлөлийг байгуулна.

4.2.3. Аймгийн томоохон худалдааны төв, гудамж талбайг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2.4. Цагдаагийн байгууллагын алба хаагчдыг шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангаж, унаажуулах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ.

4.2.5. Аймаг, сумдад олон нийтийн цагдаа ажиллуулах санал, санаачилгыг дэмжин ажиллана.

4.2.6. Архангай аймгийн Булган сумын нутаг дэвсгэрт цагдаагийн алба хаагчдын хээрийн дадлага сургуулилыг хийх сургалтын төвийг барих ажилд дэмжлэг үзүүлнэ.

4.2.7. Шүүхийн шинжилгээний чанарыг дээшлүүлж, гэмт хэргийг цаг алдалгүй түргэн шуурхай илрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2.8. Тарны гүүрний хяналтын постын үйл ажиллагааг тогтмолжуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана.

4.2.9. Сумдын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагууд болон Засаг даргын Тамгын газрын харъяа хэлтэс, агентлагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж стандартын хэрэгжилтийг хангуулан Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгоно.

4.2.10. Ажилтнуудын ажлын бүтээмжийг дээшлүүлж, “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

4.2.11. Хэрэглэгчийн эрх ашиг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тогтмолжуулж, тэдний эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлнэ.

4.2.12. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлнэ.

4.2.13. Гал унтраах автомашин техник, багаж хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

4.2.14. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор баталсан “Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

4.2.15. Аймгийн гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын сургуулийг 3 суманд зохион байгуулна.

4.3. Батлан хамгаалах салбарын чиглэлээр:

4.3.1. Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс, Батлан хамгаалахын багц хуулиудыг нийт ард иргэдэд сурталчлан таниулж, иргэдтэй эх оронч үзэл, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллана.

4.3.2. Экологийн сүйрлээс сэрэмжлэн хамгаалах, ойжуулах, цөлжилттэй тэмцэх, байгалийг нөхөн сэргээх зэрэг үйл ажиллагаанд цэргийн дүйцүүлэх албаны оролцоог нэмэгдүүлэх замаар дэмжлэг үзүүлнэ.

4.3.3. Дайчилгааны бэлэн байдлыг дээшлүүлэн дайчилгааны бэлтгэл, нөөцийн бүрэлдэхүүнийг нэмэгдүүлж, сургалт, дадлагыг сайжруулна.

4.4. Гадаад харилцааны чиглэлээр:

4.4.1. Төрийн байгууллагуудын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, шинэ технологи, судалгаа, хүний нөөцийн сургалт, тоног төхөөрөмжийн шинэчлэлд хамтран ажиллаж сайн түншлэлийг бий болгоно.

4.4.2. Төрийн албан хаагчид, шаардлагатай салбарын мэргэжилтнүүд, оюутнуудыг гадаад арга хэмжээнд оролцуулах, туршлага судлуулах, сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах ажлыг зохион байгуулна.

Анхаарал тавьсанд баярлалаа.